



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

ЖЕНДЭРИЙН  
ҮНДЭСНИЙ ХОРОО

# МОНГОЛ УЛС: ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ӨНӨӨГИЙН ТҮВШИН

(Сүүлийн үеийн тоо баримтаар)



67,62

ДУНДАЖ НАСЛАЛТ

76,85

56,744

ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД  
СУРАЛЦАГЧИД

88,601

63,2%

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН

48,6%

15,089

ӨРХ ТОЛГОЙЛСОН ГАНЦ БИЕ ЭЦЭГ, ЭХ

66,648



2024 он


# ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ МОНГОЛ УЛСАД

(2023 оны байдлаар)

Монгол Улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого нь эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг хангах нөхцөлийг бүрдүүлэх, жендэрийн ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, түүнийг арилгахад чиглэж байна.



## 1. МОНГОЛ УЛС ЖЕНДЭРИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ОЛОН УЛСАД

Дэлхийн Эдийн Засгийн форумын 2023 оны дэлхийн жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлтээр Монгол Улс 0.704 оноотойгоор 146 орноос 80 дугаар байранд жагссан бөгөөд энэхүү үзүүлэлтийг дөрвөн үндсэн хэмжигдэхүүн болох эдийн засгийн оролцоо ба боломж, боловсролын түвшин, эрүүл мэнд ба эсэн мэнд амьдрах чадвар, улс төрийн эрх мэдэл хоорондын жендэрт суурилсан ялгааны хувьслыг харьцуулан гаргадаг. (The World Economic Forum, 2023)



2023

Жендэрийн зөрүүтэй байдлын индекс	80	0.704
Эдийн засгийн оролцоо ба боломж	33	0.745
Боловсрол эзэмшилт	67	0.994
Эрүүл мэнд ба амьд гарах боломж	1	0.980
Улс төрийн эрх мэдэл	121	0.099

Монгол Улс   
Дэлхийн дундаж 

# 2022



## Жендэрийн хөгжлийн индекс

# 0.997



## Жендэрийн тэгш бус байдлын индекс

# 0.276

### Жендэрийн хөгжлийн индекс 2015-2022



Жил бүр хүний хөгжлийн илтгэлээр улс орны жендэрийн хөгжлийн индексийг тооцож байгаа нь тухайн улс орны жендэрийн талаар хууль эрх зүй, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнг харуулж байдаг. Манай улсын Жендэрийн хөгжлийн индекс 2022 онд 0.997 болж, 2015 онтой харьцуулахад 0.046 нэгжээр буурсан байна.

### Жендэрийн тэгш бус байдлын индекс

Манай улсын жендэрийн тэгш бус байдлын индекс 2022 онд 0.276 болж, 2015 онтой (0.289) харьцуулахад 0.013 нэгжээр буурсан байна.




Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангаж, Тогтвортой хөгжлийн зорилт 2030-ын хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхэд эмэгтэйчүүдийн улс төр дэх төлөөлөл болон ажиллах хүчний оролцооны түвшин хангалтгүй байна. Тухайлбал ажиллах хүчний оролцооны түвшинд эмэгтэйчүүдийн (51.5 хувь) эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс (66.4 хувь) 14.9 нэгж хувиар доогуур байна. (Үндэсний статистикийн хороо, 2024) Энэ нь эмэгтэйчүүд хөдөлмөр эрхлэх боломжийн хувьд болон цалин хөлс, орлогын хувьд жендэрийн ялгаатай байдлыг харуулж байна.

### Парламентад суудалтай эмэгтэйчүүдийн эзлэх хувь

	Нийт нэр дэвшигчид	Үүнээс эмэгтэй	Үүнээс эрэгтэй
1992	293	4	289
1996	302	8	294
2000	602	9	593
2004	244	5	239
2008	256	66	190
2012	544	174	370
2016	498	129	369
2020	606	151	455


### 2020 оны УИХ-д сонгогдсон гишүүдийн хүйсийн харьцаа



Монгол Улсын нийт сонгогчдын 51%-ийг эмэгтэйчүүд бүрдүүлдэг бөгөөд тэд сонгуульд идэвхтэй оролцдог. Гэвч УИХ дахь тэдний төлөөлөл нь ердөө 17.1% буюу дэлхийн дунджаас 7.6%-аар бага байна.

Эх сурвалж: Сонгуулийн Ерөнхий Хороо 2021

## Монгол Улсын Их хурлын гишүүд, хүйсээр, сонгуулийн онуудаар



Нийт эмэгтэй нэр дэвшигчдээс 2020 онд парламентын гишүүдийн 17.1 хувь эмэгтэй гишүүн байгаа нь эмэгтэйчүүдийн төлөөлөл улс төрийн шийдвэр гаргах түвшинд хангалтгүй байгааг харуулж байна. Эмэгтэйчүүдийн төлөөлөл, оролцоог улс төрийн шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлснээр нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх байдал сайжрах боломжтой юм.

*Эх үүсвэр: Сонгуулийн ерөнхий хороо, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн дүн, ҮСХороо*



## Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалт

Жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний дотор гэр бүлийн хүчирхийлэл буурахгүй байна. Манай улсын хувьд анх удаа 2017 онд явуулсан судалгаагаар хамтрагчтай эмэгтэйчүүдийн 29,7% нь амьдралдаа бие махбодын хүчирхийлэлд өртсөн бол 17,3% нь бусдын зүгээс үйлдсэн хүчирхийлэлд өртсөн байна. Монгол Улсад гурван эмэгтэй тутмын нэг (31.2%) нь амьдралынхаа туршид бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртжээ. Гэр бүлийн хүрээнд тухайлбал, нөхөр/хамтрагчийн зүгээс 10 эмэгтэй 6 нь (57.9%) амьдралынхаа туршид хүчирхийлэлд өртжээ.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2023 онд гэр бүлийн хүчирхийлэл /11.7/-ийн 126 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 28,6% аар өссөн байна. (Цагдаагийн ерөнхий газар, 2024)

### Хамтрагчийн зүгээс хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдийн эзлэх хувь, хүчирхийллийн хэлбэрээр, дүнд эзлэх хувиар




Эх үүсвэр: ҮСХорооны "Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа-2017", ЦЕГ-ын Статистикийн тойм "Гэр бүлийн хүчирхийлэл"-2020




Эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 9.23 жилээр богино болоод байгаа нь ноцтой асуудал юм.

Монгол улс зөрүү хамгийн их орнуудаас **12-т**, Зүүн Ази, Номхон Далайн бүсийн орнуудаас **2-т** жагсаж байна.



Эх сурвалж: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрүү 1992 онд 4.19 байсан бөгөөд 2019 онд 9.58 байсан бол 2023 онд 0.35 нэгжээр буурч 9.23 болсон байна.



Эх үүсвэр: ҮСХороо, [www.1212.mn](http://www.1212.mn).



## 2. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ОРЧИН, УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### А. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГЫН ОРЧИН

- БНМАУ-ын 1924 оны анхны Үндсэн хуульд эмэгтэй эрэгтэй хүмүүст тэгш шударга хандах талаар тусгасан нь 1992 оны Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөний гүнзгийрүүлсэн агуулгаар уламжлагдсан бөгөөд уг үзэл баримтлалын дагуу Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг 2011 онд баталсан.
- Тус хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг 2021 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд хэрэгжилт “дундаас доогуур” буюу хангалтгүй гэж үнэлэгдсэн. Үүнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлалыг салбарын болон тухайн харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид тусгаж, бүрэн нэвтрүүлээгүй байдал нөлөөлснийг үндэслэн Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай, Хууль зүйн туслалцааны тухай, Улс төрийн намын тухай (шинэчилсэн найруулга) зэрэг хуулиудад жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан холбогдох зохицуулалтыг баталгаажуулж тусгаад байна.
- Монгол Улсын Засгийн газраас Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөг (2013-2016), Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг (2002-2015), (2017-2021) онуудад баталж үе шаттай хэрэгжүүлсэн. Бодлогод суурилсан төлөвлөгөөт үйл ажиллагааны хүрээнд 1996 оны Эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай үндэсний хөтөлбөрөөс эхлэн тооцвол жендэрийн тэгш байдлын чиглэлээр нийтдээ 4 хөтөлбөрийн хэрэгжилт дуусгавар болжээ.

- Батлагдсан хууль, бодлого хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй хэрэгжүүлэх, үр нөлөөг нь жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалын хувьд үнэлэх практик туршлагыг бэхжүүлэхэд салбар дундын зохицуулалт, хамтын ажиллагаа туйлын чухал болохыг харгалзан Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Жендэрийн үндэсний хорооноос “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө” (2022-2031)-г баталлаа. (Жендэрийн үндэсний хороо, 2022)
- Монгол Улсын жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх үндсэн гол хөшүүрэг бол Жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг хувийн хэвшлийн байгууллагын бодлого төлөвлөлтөд нэвтрүүлэх явдал юм. Энэ хүрээнд хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, боловсрол, хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр зэрэг салбарын жендэрийн бодлогын хэрэгжилтийн үнэлгээ, Хөдөлмөрийн тухай хуулийн жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой заалтуудыг аж ахуйн нэгж, байгууллагуудад хэрэгжүүлж буй сайн туршлагын судалгааг үндэслэн “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого (2022-2031)-ыг Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-тай нийцүүлэн боловсруулж, Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2022 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 38 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилтийг эхлүүллээ.
- 2013 оноос эхлэн салбар, орон нутгийн жендэрийн тусгайлсан бодлого, төлөвлөлтийг хөгжүүлж, одоогийн байдлаар 14 салбарт жендэрийн стратеги, бодлого, 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт оролцоонд суурилан боловсруулсан жендэрийн дэд хөтөлбөр хэрэгжиж, 50%-тай буюу эрчимжүүлэх шаардлагатай байна.

**Монгол Улс жендэрийн тэгш байдалд чухал ач холбогдолтой олон улсын дараах конвенцид нэгдэн орсон.**

**Үүнд:**

Нэгдэн орсон он	Конвенцийн нэр
1965	<ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай конвенц (1952) /1952 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталж, 1954 оны 7 сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> </ul>
1969	<ul style="list-style-type: none"> <li>Тэгш шан хөлс олгох тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 100 дугаар конвенц (1951) /1951 оны 6 дугаар сарын 29-ний өдөр баталж, 1953 оны 5 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> <li>Эхчүүдийг хамгаалах тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 103 дугаар конвенц (1952) /1952 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталж, 1955 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> <li>Алагчилахгүй байх /ажил, мэргэжил, хөдөлмөр эрхлэлт/ тухай олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц (1958) /1958 оны 6 дугаар сарын 25-ны өдөр баталж, 1960 оны 6 дугаар сарын 15-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> </ul>
1974	<ul style="list-style-type: none"> <li>Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (1966) /Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> <li>Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт (1966) /Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200A (XXI) дугаар тогтоолоор баталж, 1976 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> </ul>
1981	<ul style="list-style-type: none"> <li>Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (1979) /Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон/</li> </ul>


## Б. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Жендэрийн харилцаа нь нийгмийн амьдралын бүх салбар, чиглэлийг хамардаг тул жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо нь салбар болон нийгмийн оролцогч талуудын үйл ажиллагааг нэгтгэн зохицуулах чадамжтай байхыг дэлхий нийтээр даган мөрддөг Бээжингийн мөрийн хөтөлбөрт чухалчлан заасан байдаг. Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг, Жендэрийн үндэсний хороо нь Монгол Улсын Засгийн газрын 2023.02.01-ний өдрийн 38 дугаар тогтоолоор ерөнхий чиг үүргийн болон чиглэлийн 8 яамны Төрийн нарийн бичгийн дарга, төрийн бусад (12) болон төрийн бус (15) нийт 35 байгууллагын 37 төлөөллийг багтаасан салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан зөвлөх чиг үүрэг бүхий дэлхийн тэргүүн туршлагын жишээ юм. Жендэрийн үндэсний хороо нь 21 аймаг, нийслэл, нийслэлийн 9 дүүрэгт 31 салбар хороо, 232 дэд салбар хороо, төрийн захиргааны 16 төв байгууллага (яамд)-д салбар зөвлөл, 21 агентлагт дэд салбар зөвлөлтэй.

Хорооны Ажлын алба нь 14 ажилтантай, төрийн захиргааны төв байгууллагад 16, орон нутагт 31 жендэрийн мэргэжилтэнтэй ажиллаж байна. Мэргэжилтнүүд Жендэрийн салбар зөвлөл, хороодод нарийн бичгийн үүрэг гүйцэтгэж, жендэрийн асуудлыг үндсэн ажлын хамт хавсран гүйцэтгэж байсан бөгөөд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газарын “Жендэрийн эрхтэгш байдлыг хангах салбар дундын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн”-ий албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2023.07.07-ний өдрийн 341 дүгээр тогтоолоор баталснаар 2023 оны байдлаар төрийн захиргааны төв 4, нутгийн захиргааны 6 байгууллагад жендэрийн бие даасан мэргэжилтэн ажиллаж байна.

## Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний тогтолцоо

ҮНДЭСНИЙ ТҮВШИНД:



ОРОН НУТГИЙН ТҮВШИНД:

### 3. ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ САНХҮҮЖИЛТ

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль батлагдсанаас хойш 2011-2019 онуудад жендэрийн асуудлаар 12,469,841 ам.долларын хөрөнгө зарцуулсны 452,000 ам.долларыг буюу 3.6 хувийг улсын төсвөөс, үлдсэн 96.4 хувийг Хөгжлийн албан ёсны туслалцаа (ХАЁТ)-ны хүрээний түншлэгчид олгожээ.

## Жендэрийн тэгш байдлыг хангах санхүүжилт, үйл ажиллагааны чиглэлээр, 2011-2019



Эх үүсвэр: Монгол Улсад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр 2011-2019 онд хоёр болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, санхүүжилтийн тойм.

## 2019-2022 оны санхүүжилтийн байдал (мянган төгрөгөөр)

Он	Улсын төсөв: ЖҮХ-ны Ажлын албаны төсөв санхүүжилт	Улсын төсөв: Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн санхүүжилт	Орон нутгийн санхүүжилт	Олон улсын байгууллага, төслийн санхүүжилт (ЖҮХ-ны Ажлын алба)	Яамдын санхүүжилт	Бүгд
2019	406,809.3	300,000.0	766,100.0	232,204.4	464,000.0	2,169,113.7
2020	355,900.0	200,000.0	478,400.0	489,000.0	-	1,523,300.0
2021	350,705.4	0	2,200,614.9	415,492.7	45,331.9	3,012,145.0
2022	277,705.6	0	2,321,671.0	639,834.0	434,754.0	3,673,965.0

## 4. ТҮНШЛЭЛ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангах үүрэг бүхий байгууллагууд, түүний дотор Жендэрийн Үндэсний Хорооны Ажлын алба нь үйл ажиллагааныхаа хүрээнд дотоод, гадаадын төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо бүхий өргөн хүрээтэй түншлэлийг хөгжүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд Тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд жендэрийн тэгш байдлыг хөгжлийн үндсэн арга стратеги хэмээн үзэж бодлого, үйл ажиллагааныхаа чухал хэсэг болгодог Нэгдсэн Үндэсний Байгууллагын тогтолцооны байгууллагууд, түүний дотор олон улсын санхүүгийн байгууллагууд, түүнчлэн Хөгжлийн албан ёсны туслалцааны хоёр талт бүх байгууллагатай хамтран ажиллаж байна.

- Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 77 дугаар захирамжаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хөгжлийн бодлогын үйл ажиллагааг тодорхойлох, хэрэгжүүлэхэд стратегийн дэмжлэг үзүүлэх, зөвлөх чиг үүрэг бүхий “Бодлогын зөвлөл”-ийг Жендэрийн үндэсний хорооны дэргэд байгууллаа. Энэхүү зөвлөлд УИХ-ын 13 эмэгтэй гишүүд болон Засгийн газрын эмэгтэй гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөхүүд болоод УИХ-д суудалтай улс төрийн намуудын дэргэдэх эмэгтэйчүүдийн холбоодын тэргүүн нарын төлөөллүүдээс бүрдэнэ. (Жендэрийн үндэсний хороо, 2021)
- Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд жендэрийн квотыг нэмэгдүүлэх, Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасан чиг үүргийг тусгах чиглэлд бүхий л түвшинд хамтран ажиллалаа. УИХ-д “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих лобби бүлэг”-ийг байгууллаа.
- Жендэрийн үндэсний хорооны 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө” (2022-2031)-ний хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Жендэрийн үндэсний хорооны орлогч даргаар ахлуулан нийт 19 гишүүний бүрэлдэхүүнтэй Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 205 дугаар захирамжаар байгуулж, төлөвлөгөөний зорилго, дэд зорилт бүрээр техникийн 5 дэд ажлын хэсэг байгууллаа. (Жендэрийн үндэсний хороо, 2023)

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7-д зааснаар Засгийн газар нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг Улсын Их Хуралд 2 жил тутам тайлагнах, тайлан бэлтгэх ажлыг Жендэрийн үндэсний хороо үндэсний хэмжээнд зохион байгуулах үүрэгтэй байдаг. Монгол Улсын Засгийн газар хууль батлагдсанаас хойш 2021 онд анх удаа Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороогоор Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн, хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хэлэлцүүлсэн бол 2023 онд хоёр дахь удаагийн тайланг Нийгмийн бодлогын болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанд танилцуулж, хэлэлцүүллээ. (Жендэрийн үндэсний хороо, 2023)
- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайлан хэлэлцүүлсэнтэй холбогдуулан Жендэрийн үндэсний хорооны 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 2 дугаар тогтоолоор Хорооны гишүүдэд доорх чиглэлийг өгөв (Жендэрийн үндэсний хороо, 2024). Үүнд:
  1. Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах чиглэлээр дараагийн шатны тусгайлсан төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг жендэрийн салбар хороо, салбар зөвлөлийн дарга, Хорооны гишүүдэд;
  2. Боловсролын тэгш бус байдал, ялангуяа хүйсийн ялгаатай байдалд дүн шинжилгээ хийж, цаашид хөвгүүдийн боловсролын чанар, хүртээмжийн зөрүүний шалтгаан, нөхцөлийг судалж, бодит ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны яаманд;
  3. Хөдөө, орон нутаг дахь малчид, малчин өрхийн гэр бүлийн тогтвортой байдлыг хангах хүрээнд боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх чиглэлээр тусгайлсан бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам болон Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд;
  4. Боловсролын ерөнхий хууль, Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулга энэ оноос хэрэгжиж байгаатай холбогдуулан бүх нийтийн жендэрийн болон эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч ажиллахыг Хорооны гишүүдэд;
  5. Төрөөс баримтлах жендэрийн бодлого, хууль тогтоомж, хөгжлийн бодлого төлөвлөлтийг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлэх болон жендэрийн тэгш бус байдал үүсэж буй асуудлаар Хорооны орлогч дарга болон жендэрийн үндэсний шинжээч, мэргэшсэн эрдэмтэн судлаачдын багийн



төлөөллийг оролцуулсан зөвлөлдөх уулзалтыг тогтмол зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргад;

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбарын болон орон нутгийн жендэрийн бодлого төлөвлөлтийн хэрэгжилтийн явцыг үнэлэх, хөндлөнгийн үнэлгээг төрийн бус байгууллага, судалгааны байгууллагаар гүйцэтгүүлж ажиллахыг зөвлөж ажилласны дүнд хэрэгжилтийн хугацаа дууссан болон эхний үе шат дууссан 9 салбарын бодлого, 11 орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд хөндлөнгийн болон дотоод хяналт шинжилгээ хийгдлээ.
- Гадаадулсын Засгийн газар, олон улсын байгууллагаас жендэрийн асуудлаар хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, үйл ажиллагаа, цаашид дэмжлэг шаардлагатай асуудлыг хамтран тодорхойлох, хөгжлийн санхүүжилтийн уялдааг хангах зорилгоор Хорооны Ажлын алба 2019 оноос Хөгжлийн түншлэгчдийн уулзалтыг улирал тутам зохион байгуулж байна. Тус хөгжлийн түншлэгчдийн уулзалтыг 2024 оноос эхлэн салбарын хүрээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн жендэр, нийгмийн үр нөлөөг дээшлүүлж, үндэсний болон салбарын жендэрийн бодлого төлөвлөлттэй уялдуулах зорилгоор төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн.
- 2019-2024 онуудад Жендэрийн үндэсний хорооны ажлын албанаас олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран дараах төслүүдийг хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:
  - Европын холбооны санхүүжилтээр НҮБ-ын Хүн амын сантай хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсад жендэрийн тэгш байдлын үндэсний чадавхыг бэхжүүлэх нь” төсөл /2024-2025/
  - Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах болон жендэрийн бодлогоор дамжуулан хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн жендэрийн тэгш байдлыг сайжруулах” төсөл /2024-2026/
  - БНСУ-ын КОЙКА олон улсын байгууллагын санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж буй “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төсөл /2021-2024/
  - Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр “Төв Азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүд хөтөлбөр” төсөл /2021-2024/.
- Жендэрийн үндэсний хорооны гишүүн төрийн бус байгууллагууд, бусад хүний эрхийн болон хүний хөгжлийн чиглэлээр ажилладаг Төрийн бус байгууллагуудтай дараах чиглэлээр тогтвортой хамтран ажиллаж байна.

Үүнд:

- Жендэрийн дүн шинжилгээ, түүний дотор төрийн албан дахь жендэрийн тэгш байдлын асуудлаар судалгаа үнэлгээ хийх;
  - Жендэрийн бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;
  - Жендэрийн тэгш байдлыг хангах эрхзүйн бодлогын орчныг сайжруулах, сургалтын тогтолцоог хөгжүүлэх;
  - Улс төр, нийгэм, соёлын хүрээнд, түүний дотор шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт нөлөөлөл хийх;
  - Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй, түүний дотор ажлын байрны бэлгийн дарамттай тэмцэх;
  - Нутгийн өөрөө удирдах байгууллагын бодлого, үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлал нэвтрүүлэх.
- Жендэрийн үндэсний хороонь Улс төрийн намын тухай хууль/шинэчилсэн найруулга/-д заасан зохицуулалтын хүрээнд улс төрийн намын бодлого үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, хуульд заасан тайлан мэдээллийг хүлээн авахтай холбогдуулан арга зүйн дэмжлэг үзүүлэх замаар улс төрийн намуудтай хамтран ажиллаж эхлээд байна. Энэ хүрээнд:
    - **“Жендэрийн тэгш байдлыг хангахад улс төрийн намын оролцоо, манлайлал”** үндэсний форумыг анх удаа зохион байгуулж, намуудын хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлов.
    - Улс төрийн намын байгууллагуудын гишүүдийн хүйсийн тэнцвэрт байдлын тайлангийн маягтыг Үндэсний Статистикийн хороогоор батлуулахаар ажиллаж байна.
    - Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд заасны дагуу Монгол ардын нам, Иргэдийн оролцооны нэгдэл нам, ХҮН нам анх удаа тайлан мэдээллийг Жендэрийн үндэсний хороонд ирүүллээ. Энэ нь хууль батлагдсанаас хойш 11 жилийн дараа ахиц дэвшил гарсан үзүүлэлт бөгөөд тус тайланг Жендэрийн үндэсний хорооны вэб сайтад байршуулж, олон нийтэд нээлттэй танилцууллаа.

**Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйн удирдлагаар хангах зорилгоор жендэрийн эрх тэгш байдлыг хангахад шаардлагатай үндэсний чадавхыг төрийн байгууллагын болон нийгмийн хүрээнд бэхжүүлэхэд чиглэсэн зөвлөмж, үлгэрчилсэн загвар, аргачлал, судалгаа зэрэг шинжлэх ухааны үндэслэлтэй бүтээлүүдийг жил бүр эрхлэн гаргадаг.**

Он	ЖҮХАА-аас 2020-2023 онд эрхлэн гаргасан хэвлэлийн бүтээгдэхүүний жагсаалт
2020	Орон нутгийн жендэрийн дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал
2020	Салбарын жендэрийн бодлогод оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал
2020	Жендэрийн тэгш байдлын өнөөгийн түвшин /сүүлийн үеийн тоо баримтаар/
2020	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлого төлөвлөлт, төсөвлөлт
2020	Жендэрийн салбар хорооноос орон нутгийн хэмжээнд ЖЭТБХанган ажиллах удирдамж
2020	Монголын бичил болон жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд Ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ
2021	Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй холбоотой гомдлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын хүрээнд хянан шийдвэрлэх талаарх аргагүйн зөвлөмж /төрийн албан хаагчдад болон төрийн байгууллагаас бусад бүх хуулийн этгээдийн удирдлага, ажилтан, ажил олгогч иргэнд зориулав/
2021	Жендэрийн тэгш байдлыг хангах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх
2021	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээрх орон нутгийн сайн туршлага
2021	Жендэрийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмын үлгэрчилсэн загвар
2021	Жендэрийн салбар хорооны бүрэлдэхүүн ажиллах журмын үлгэрчилсэн загвар
2021	Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд ЖЭТБХангах үзэл баримтлалыг нэвтрүүлэх нь
2021	Жендэрийн мэдрэмж, ёс зүйтэй сэтгүүл зүй удирдамж /редакцуудад зориулсан удирдамж/
2021	ЖСХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хөвгүүд, эрчүүдийг татан оролцуулах сургагч багш бэлтгэх модуль хөтөлбөр
2021	Жендэр судлал №3-4
2021	Жижиг, дунд, бичил бизнес эрхлэгчдэд зориулсан гарын авлага
2021	Жендэр ба нийгмийн ажил /нийгмийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулиудад зориулсан модуль сургалтын гарын авлага/
2021	Жендэрийн мэдрэмжтэй сэтгүүл зүй
2021	Эрэгтэй, эмэгтэй залуу малчдын амьдрал ахуй дахь жендэрийн дүн шинжилгээ
2023	Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого
2023	Жендэрийн нэр томьёо тодорхойлолт, үндсэн ойлголтуудын тайлбар толь

([www.ncge.gov.mn](http://www.ncge.gov.mn) сайтын ном эмхтгэл хэсэгт)

## 5. ЖЕНДЭРИЙН СТАТИСТИК

Статистик үзүүлэлтүүд улсын дүн	Эмэгтэй	Эрэгтэй	Эх сурвалжийн он
1. Монгол Улсын нийт хүн амын тоо	1 786 466	1 718 275	2023
2. Өрх толгойлсон ганц бие эцэг, эх	66.648	15 089	2022
3. Төрөлтийн тоо	32177	34 057	2023
4. Нас баралтын тоо	7 111	11 930	2023
5. Дундаж наслалт	76.85	67.62	2023
6. Нас баралтын зонхилох шалтгаан (зарим)			
Зүрх судасны тогтолцооны өвчин	2 338	3505	2022
Хавдар	1776	2526	
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	634	2726	
Амьсгалын тогтолцооны өвчин	326	565	
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	528	709	
7.15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо	562 066	634 771	2023
8. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	48.6%	63,2%	2023-4
9. Ажилгүйдлийн түвшин	5.8%	7.4%	2022
10. Аж ахуйн нэгж байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин	1 979.1 мян.төг	2.479.8 мян.төг	2023-4
11. Ажлын байр дахь хүнд болон хөнгөн осол гэмтлийн давтамжийн хувь			2022
Үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан амь нас хохирсон Үйлдвэрлэлийн ослоос шалтгаалан амь нас хохироогүй	1.1% 18.5%	8.1% 37.6%	
12. Ерөнхий боловсролын сургуульд өдрөөр суралцагчид	371 500	374 900	2023
13. Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид	14 115	24 179	2023
14. Их, дээд сургууль, коллежид суралцагчид	88 601	56 744	2023
15. Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо	16 099	19 121	2022
16. УИХ-ын гишүүд	13	63	2021

17. Засгийн газрын гишүүд	3 14.3% (квот хангагдаагүй)	18 85.7%	2023
18. Дэд сайд нар	3 18.75% (Квот хангагдсан)	13 81.25%	2023
19. Яамдын Төрийн нарийн бичгийн дарга	5 31.25% (Квот хангагдсан)	11 68.75%	2023
20. Засгийн газрын агентлагийн дарга	6 23%	20 77%	2023
21. Яамдын газар, хэлтэс, албадын дарга	160 (Квот хангагдсан)	150	2023
22. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /аймаг, нийслэл/	2 9.09%	20 90.9% 86.45%	2023
23. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /дүүрэг/	3 33.3%	6 66.6%	2023
24. Засаг дарга /аймаг, нийслэл/	1 0.22%	21 99.78%	2023
25. Засаг даргын орлогч /аймаг, нийслэл/	3 13.6%	19 86.4%	2023
26. Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга	6 27.3%	16 72.7%	2023
27. Засаг дарга /дүүрэг/	1 11.2%	8 88.8%	2023
28. Засаг даргын орлогч /дүүрэг/	3 33.3%	6 66.6%	2023
29. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга	1 11.1%	8 88.9%	2023
30. Засаг дарга /сум/	49 17.4%	281 82.5%	2023
31. Жендэрийн хөгжлийн индекс		0.997	2022
32. Жендэрийн тэгш бус байдлын индекс		0.276	2022

Эх сурвалж: (www.1212.mn)



<http://www.ncge.gov.mn>



Хаяг / Байршил: Монгол Улс,  
Улаанбаатар 14200-0063, Сүхбаатар дүүрэг,  
6-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-20,  
Жендэрийн үндэсний хорооны байр  
Утас: (976) 70071116  
И-мэйл: [secretariat@ncge.gov.mn](mailto:secretariat@ncge.gov.mn)  
Вэб сайт: <http://www.ncge.gov.mn>



NATIONAL COMMITTEE  
ON GENDER EQUALITY

# MONGOLIA: GENDER EQUALITY STATUS

( Recent by data )



67,62

AVERAGE LONGEVITY

76,85

56,744

UNIVERSITY AND COLLEGE STUDENTS

88,601

63,2%

EMPLOYMENT RATES

48,6%

15,089

HEAD OF HOUSEHOLD SINGLE PARENTS

66,648



2024

© National Committee on Gender Equality, Government of Mongolia

**Address:** Mongolia, Ulaanbaatar 14200-0063  
Sukhbaatar district, 6th committee,  
United Nations street 20, Building of NCGE

**Tel:** (976) 70071116

**E-mail:** [secretariat@ncge.gov.mn](mailto:secretariat@ncge.gov.mn)

**Web site:** <http://www.ncge.gov.mn>

Printed at "BGM" printing house.

Ulaanbaatar city, 2024




# GENDER EQUALITY IN MONGOLIA

(As of 2023)

Mongolia's state policy on gender equality aims to create conditions for equal opportunities and equal treatment for men and women, as well as for the prevention and elimination of gender discrimination.

## 1. MONGOLIA IN THE LIGHT OF INTERNATIONAL GENDER INDICES

